

“ГОЛОМТ БАНК” ХК-ИЙН 2026 ОНЫ 2-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН НИЙТЛЭГДЛЭЭ

Монгол улс, Улаанбаатар хот – (2026.07.20) “Голомт банк” ХК-ийн 2026 оны 2-р улирлын санхүүгийн тайлан нийтлэгдлээ.

2026 оны эхний хагас жилийн байдлаарх макро-эдийн засгийн үзүүлэлтүүд:

- Монгол Улсын эдийн засаг 2026 оны эхний саруудад өсөлтийн эрчээ хадгаллаа. 2025 онд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 6.8 хувиар өссөн нь хүлээлтээс өндөр үзүүлэлт болсон бөгөөд үүнд хөдөө аж ахуй болон уул уурхайн салбарын өсөлт голлон нөлөөлсөн. Харин 2026 оны I улиралд эдийн засгийн өсөлт 7.9 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеийн 2.6 хувийн өсөлтөөс мэдэгдэхүйц нэмэгдсэн үзүүлэлт болж байна.
- Уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүч хэвээр байж, 2026 оны I улирлын ДНБ-ий өсөлтөд ойролцоогоор 5 нэгж хувийг эзэлсэн байна. Тухайлбал, 2025 оны сүүлийн хагасаас эхлэн нүүрсний экспорт сэргэсний зэрэгцээ Оюу толгойн далд уурхайн олборлолтын хүрээнд зэсийн үйлдвэрлэл огцом нэмэгдсэн нь уул уурхайн салбарын өсөлт эрчимжихэд хүргэсэн юм. 2026 оны эхний хагасын байдлаар зэсийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс хоёр дахин нэмэгдсэн бол нүүрсний экспортын орлого 54.2 хувиар өсөж, нийт экспортын орлогын өсөлтийг дэмжив.
- Гадаад худалдааны тэнцэл 2026 оны эхний 6-р сард 4.277 сая ам.долларын ашигтай гарав. Нэг талаас уул уурхайн салбар эрчимжсэнээр экспортын өсөлт 57.9 хувьд хүрсэн бол нөгөө талдаа шатахууны импортын зардал нэмэгдсэнээс шалтгаалж нийт импортын өсөлт сүүлийн саруудад бага зэрэг нэмэгдэж, 10.6 хувьд хүрлээ. Гэсэн ч экспортын өсөлт харьцангуй өндөрт хадгалагдаж байгаагаас гадаад худалдааны ашиг өнгөрсөн оны мөн үеэс 4 дахин нэмэгдээд байна.
- 2026 оны эхний хагаст хүнс, шатахууны үнийн өсөлтийн нөлөөгөөр инфляц эрчимжиж, 6-р сард жилийн инфляц 12.0 хувьд хүрэв. Үүнтэй холбоотойгоор Монголбанк 6-р сард бодлогын хүүг 12.0 хувьд хэвээр хадгалсан ч Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээний нөлөөгөөр инфляцын эрч оны эцэст алгуур сулрах хүлээлттэй байна.
- Эдийн засгийн өсөлт 2026 онд уул уурхайн салбар болон томоохон дэд бүтцийн төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр 5-6 орчим хувьд тогтвортой хадгалагдах төлөвтэй байна. Гэсэн ч дэлхийн эдийн засаг дахь геополитикийн тодорхойгүй байдал, улс хоорондын худалдааны бодлого, эрчим хүчний зах зээлийн төлөв зэрэг нь түүхий эдийн үнэ, гадаад эрэлтээр дамжин манай эдийн засгийн төлөвт нөлөөлөх эрсдэл өндөр хэвээр байна.

Голомт банкны 2026 оны 2-р улирлын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад :

- Нийт актив 4.9 их наяд төгрөг буюу 32.9%-аар өсөж 19.9 их наяд төгрөгт хүрэв.
- Нийт зээлийн багц 728 тэрбум төгрөг буюу 9.0%-аар өсөж, 8.9 их наяд төгрөгт хүргэв. Үүний 55%-ийг байгууллагын зээл, 45%-ийг иргэдийн зээл эзэлж байна.
- Чанаргүй зээлийн харьцаа 2.7%-аас буурч, 2.5%-д хүрч сайжрав.
- Харилцагчийн эх үүсвэр 2.2 их наяд төгрөг буюу 25.3%-аар өсөж 11 их наяд төгрөгт хүрэв.
- Хөрөнгө оруулалтын багц 75.5%-аар өсөж, 2.4 их наяд төгрөгт хүрэв.
- Нийт өөрийн хөрөнгө 21.1%-аар өсөж, 1.7 их наяд төгрөгт хүрэв.
- Татварын дараах цэвэр ашиг 134.2 тэрбум төгрөгт хүрч, жилээр илэрхийлсэн дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 16.5% байна.
- Монголбанк болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.

Тайлантай танилцахыг хүсвэл [ЭНД](#) дарж зочилно уу.

Банкны тухай нэмэлт мэдээллийг дараах сувгуудаар авах боломжтой: www.golomtbank.com/investor-relations

| X: [@golomtbank](#) | LinkedIn: www.linkedin.com/company/golomtbank

| YouTube: www.youtube.com/golomtbank

| Facebook: www.facebook.com/Golomtbank